

● ● ● COAL MINING

COKING COAL

LOOSE COKING

ENERGY COAL

COKE



ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Үйл ажиллагааны
мэдээлэл

Тавантолгой бүлэг ордод
Нүүрс олборлолт, Кокс боловсруулалт

Тусгай зөвшөөрлийн
мэдээлэл

Дугаар: MV-000287/А, Хэмжээ : 276,9 га

Өмчийн хэлбэр

Хувьцаат компани

51% - Өмнөговь аймаг /орон нутаг/

49% - Бусад хувьцаа эзэмшигч /МХБирж/

Уурхайн хүчин чадал

5-10 сая тонн нүүрс олборлон, борлуулах

Компанийн хаяг

Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг




1966 55th 2021

- Тавантолгой ХК нь 1966 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Тавантолгойн нүүрсний ордыг анхлан эзэмшигч юм. 1994 онд Засгийн газрын өмч хувьчлалын 42 тоот тогтоолоор хувьцаат компани болгож 1995 оноос Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн одоогоор орон нутгийн өмч давамгайлсан /51%/ хувьцаат компани болон ажиллаж байна.
- Компани Тавантолгой нүүрсний орд газрын MV-000287/A дугаар бүхий 276,9 га талбайд олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулж байна. 2015 онд Эрдэс баялагийн зөвлөлд тусгай зөвшөөрлийн талбай дахь нөөцийг батлуулсан бөгөөд тус талбайд нийт 195.4 сая.тн нүүрсний нөөцтэй нь тогтоогдсон. Уурхай байршлын хувьд Улаанбаатар хотоос 550км, Даланзадгад хотоос 98км, Цогтцэций сумаас 15км-т Цэций уулын баруун хойно байрладаг.
- 2021 оны хувьд 5.5 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөг боловсруулан ажилласан.



1966 55th 2021

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НҮҮРСНИЙ МЭДЭЭЛЭЛ /2019, 2020 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД/



МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТОД /ТАВАНТОЛГОЙ ХК/





Нүүрс олборлолт

1.64 сая
тонн



Хөрс хуулалт

17.7 сая метр
куб



Борлуулалтын орлого

179.3 тэрбум
төгрөг



Цэвэр ашиг

13.8 тэрбум
төгрөг



Төсөвт төлсөн татвар

101.9 тэрбум
төгрөг



Зах зээлийн үнэлгээ

400.2 тэрбум
төгрөг



1966 **55th** 2021


НҮҮРС БОРЛУУЛАЛТ

/сая тонн/



ХӨРС ХУУЛАЛТ

/сая метр куб/



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

/тэрбум төгрөг/



ЦЭВЭР АШИГ


/тэрбум төгрөг/



ӨНГӨРСӨН ОНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД


НҮҮРС БОРЛУУЛАЛТ

/мян.тн/




БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

/тэрбум төгрөг/




НИЙТ ХӨРӨНГӨ

/тэрбум төгрөг/



ЦЭВЭР АШИГ

/тэрбум төгрөг/



Өнгөрсөн жилээс компанийн олборлолт, борлуулалтын хэмжээ буурсан гол шалтгаан нь Цар тахлын дэгдэлтээс шалтгаалсан хилийн боомтын хорио, АМНАТ-ын өсөлт зэргээс борлуулалтын нэгж үнэ өссөн боловч, олборлолтын өртөг, нэгж бүтээгдэхүүний зардлын өсөлт нь цэвэр ашигт нөлөөлж өнгөрсөн жилээс буурсан үзүүлэлттэй гарсан.



УУРХАЙД ШУУД БОЛОН
ШУУД БУС БАЙДЛААР

1500

АЖЛЫН БАЙРЫГ БИЙ
БОЛГОН АЖИЛЛАЖ БАЙНА.

НИЙТ АЖИЛЧДЫН ТОО 206, 100% МОНГОЛ АЖИЛТАН

АЖИЛТНУУДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА




61%



39%

НАСНЫ АНГИЛАЛ



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хүрээнд доорх ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Өдөр тутмын, давтан зааварчилгааг компанийн ажилчид туслан гүйцэтгэгч компаниудын ажилтнуудад зааварчилгаа өгөх
- Туслан гүйцэтгэгч компани, нүүрс тээврийн хэрэгсэлийн улирал тутмын техникийн үзлэг шалгалт
- Мэргэжлийн байгууллагын сургалт
- Эрүүл мэндийн анхан шатны үзлэг гэсэн чиглэлүүдээр ажилласан.
- Ковид-19 цар тахлын хүрээнд уурхайн бүсийн ногоон бүс байлгах, уурхайн эрсдлийг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран арга хэмжээнүүдийг даван туулсан.

Компанийн ажилтан тус бүрт нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хамтын хамгаалах хэрэгсэлээр ханган ажилласан.

Ажилтан албан хаагчдыг Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй хамтран жил бүр бүрэн үзлэг шинжилгээнд хамруулж шаардлагатай ажилчдыг чиглэлийн дагуу эмчилгээ, сувилалд хамруулан ажилласан.


1966 **55th** 2021

БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээнд нэмэлт тодотголын хүрээн хийгдэх ажлуудыг тусган байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажилласан.

Байгаль орчны ажлыг дараах бүлэгт хуваан хэрэгжүүлсэн ба 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт хангалттай гүйцэтгэсэн болохыг мэргэжлийн байгууллагаас дүгнэгдсэн.

- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах
- Нөхөн сэргээлт
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ
- Хог хаягдлын менежмент
- Орчны хяналт шинжилгээ
 - ✓ Усны чанар
 - ✓ Агаарын чанар
 - ✓ Хөрсний чанар




1966 **55th** 2021

2021 оны хугацаанд нийт 248 өдрийн арилжаагаар компанийн хувьцаа 185.1 мянган ширхэг буюу 1372.7 сая төгрөгийн арилжаа хийгдсэн.

2021 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс ширхэгийн хувьд 70.1 мянган ширхжг буюу 61%, үнийн дүнгийн хувьд 601 сая.төг буюу 77.9%-ийн өсөлттэй үзүүлэлттэй гарсан байна.

	2020Q4	2021Q4
Нэгж хувьцааны үнэ /дундаж/, төгрөг	6,717	7,414
Нийт арилжаалагдсан хувьцаа, ширхэг	114,967	185,142
Нийт арилжааны дүн, сая.төг	771.5	1,372.7
Зах зээлийн үнэлгээ, тэрбум төг	353.7	390.4

Хаалтын ханш



Арилжигдсан ширхэг



1966 **55th** 2021



Тээвэрлэлтийн өртөг зардлыг бууруулах

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтанд ороход нүүрс тээвэрлэлтийг тасралтгүй явуулах чиглэлээр жилд 5-10 сая тонн нүүрс хадгалах, ачих зориулалт бүхий терминалын урьдчилсан судалгааг гарган бүтээн байгуулалт хийх газрын сонголт, ТЭЗҮ боловсруулах ажлуудыг хийж эхлээд байгаа. Урьдчилсан байдлаар 3 газарт бүтээн байгуулалтын судалгаа хийгдсэн бөгөөд газар зүйн болон эдийн засгийн хувьд хамгийн тогтвортой удаан хугацаанд ашиглах боломжтой хувилбарт бүтээн байгуулалтыг хийж ажиллана.



Олборлолтын өртгийг бууруулах

Уурхайн уул геологийн нөхцөл байдал буюу хөрс хуулалтын хэмжээ нэмэгдэж байгаа, зэргэлдээх уурхайн үйл ажиллагаатай уялдаж ажиллах хүрээнд хөрс хуулалтын тээвэрлэлтийн тодорхой зайд конвейерын систем ашиглах, Нүүрсийг төмөр замын терминал хүртэл тээвэрлэх төслүүд боловсруулагдаж байна.

Төслийн урьдчилсан байдлаар олборлолтын өртөг 1.18-1.25 дахин буурах боломжтой.



Үйлдвэр технологийн парк

Нүүрснийг дахин боловсруулах, угаан баяжуулах, агуулга дундажлах зэргээр уурхайн нөөцийг үр дүнтэй ашиглах, нэмүү өртөг бий болгох чиглэлээр нэлээдгүй ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Үүний бэлтгэл ажил болгон салбар чиглэл тус бүрээр зөвлөхүүдийг авч ажиллуулж байна. Холбогдох судалгааны дүгнэлтийг ТУЗөвлөлд танилцуулан дараа дараагийн арга хэмжээнүүдийг хийхээр бэлтгэж байна.





Анхаарал хандуулсанд баярлалаа



Өмнөговь аймаг
Цогтцэций сум
Цагаан-Овоо баг
Тавантолгой
Хувьцаат компани



info@tavantolgoi.mn



(976)-75355555
(976)-94001619



www.tavantolgoi.mn

2016 оны дугаар сарын 06

